

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН МЭДЭЭЛИЙН ИЛ ТОД,
НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2025 оны 6 дугаар сарын 13

Үндэслэл

Эрүүл мэндийн яамнаас ЭМХТ-ийн 2024 оны үйл ажиллагаанд хийсэн Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээг жилийн эцсийн байдлаар 70.7 хувь буюу “Хэрэгжих шатанд” гэж үнэлэн доорхи зөвлөмжийг өгсөн.

- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ыг хэрэгжүүлэн ажиллах;
- Монгол Улсын “Төрийн байгууллагын цахим хуудсанд тавигдах шаардлага MNS6285:2017” стандартыг хангах, стандартын дагуу цахим хуудсыг ажиллуулах;
- Байгууллагын хэмжээнд албан ёсны цахим хуудсыг ажиллуулах, мэдээлэл байршуулах, шинэчлэх, хяналт тавих журам боловсруулж, мөрдөж ажиллах;
- Байгууллагын албан ёсны цахим хуудсыг тогтмол ажиллуулж, мэдээллийн шинэчлэл, баяжилтыг тухай бүр, хугацаанд нь хийж, мэдээллийг үнэн зөв, бүрэн, иргэнд ойлгомжтой байхаар байршуулж хэвших;
- Байгууллагын албан ёсны цахим хуудасны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг тогтмолжуулж, эрчимжүүлэх;
- Үнэлгээгээр байршуулаагүй байсан, 0 үнэлгээ авсан мэдээллүүдийг бүрэн, ил тод байршуулах;

Энэ дагуу ХШҮА-аас зөвлөмжийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг төвийн Захирлаар батлуулсан ба Удирдлагын Шуурхай хурлаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/346 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийг тайлагнах хүснэгт” 3.7-ийн шалгуур үзүүлэлтийн дагуу ЭМХТ-ийн Цахим хуудаст байршуулсан мэдээллийг 6-р сарын 5-аас 13-ны өдрүүдэд шалгаж, үнэлгээ хийсэн.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

Тус төв нь заасан хугацаанд нийцүүлэн мэдээллээ дараах байдлаар цахим систем болон байгууллагын вэбсайт, шилэн дансны системд байршуулж нийтэд мэдээлсэн байна.

Төвийн цахим хуудаст тавигдсан зарим мэдээллийг хэрэглэгч олж үзэхэд бэрхшээлтэй, тусгай линкээр орж үздэг. Энэхүү линкийг Цахим хуудастаа байршуулаагүй.

Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал

д/д	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
1.1	эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;	Алсын хараа, эрхэм зорилго, стратеги, үнэт зүйлс, тэргүүлэх чиглэлийн мэдээллийг нээлттэй, ил тодоор тусган байршуулсан. https://hdc.gov.mn/page/55/ Шинэчлээгүй хуучин мэдээлэлтэй.	30%

1.2	чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;	Төвийн үндсэн чиг үүрэг шинэчлээгүй. (ЭМС-ын А/26 дугаар тушаалаар) Бүтцийн зургийг шинэчлэх шаардлагатай. - Монгол Улс, Улаанбаатар хот-210648, Ш/Х-187, Сүхбаатар Дүүрэг, 1-р хороо, Энхтайвны гудамж-13Б - Имэйл хаяг: admin@hdc.gov.mn - Харилцах утас: 70128801 Мэдээллийг https://hdc.gov.mn хаягт байршуулсан.	70
1.3	эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага зөвлөмж;	Судалгаа, тайлан, бүтээлийн товчоо, төлөвлөгөөний биелэлтийн тайлангуудыг ил тод нээлтэй байршуулсан. https://hdc.gov.mn/page/98 2018-2024 оны судалгаа, бүтээлийн товчоо- цахим номыг байршуулсан. Шилэн дансанд Аудитийн дүгнэлтийг байршуулсан.	70
1.4	хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;	https://hdc.gov.mn/media/files/002_mRiDeDL.pdf Эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланг байршуулсан.	70
1.5	хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;	Байхгүй.	0%
1.6	үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;	Төвийн захирлын тушаал 2024 оны 11-р сараас хойш тавигдаагүй. Хууль эрх зүй буланд төвийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа эрх зүйн актыг байршуулаагүй.	30
1.7	албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;	Захиргааны албаны албан хаагчдын АТТ байршсан. Албан хаагчдын холбогдох мэдээллүүд тавигдсан.	30
1.8	өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;	2025 оны 1-р улирлын тайлан тавигдаагүй.	30
1.9	хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;	Эрүүл мэндийн үзүүлэлт 2024 болон Статистикийн сарын мэдээ 1-5-р сар бүгд тавигдсан.	100
1.10	мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр;	4-6-р сарын мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтын зарууд байршсан.	30
Хэсгийн дундаж хувь:			46%

Хоёр.Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал

д/д	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
2.1	ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;	2025 онд сул ажлын байрны зарыг 3 удаа байгууллагын цахим хуудас болон нүүр хуудаст байршуулж олон нийтэд нээлттэй зарласан. https://hdc.gov.mn/page/64/ - Жолооч - Үйлчлэгч - Системийн админ Эдгээр зарууд нийгмийн сүлжээгээр болон Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн программ, Zangia.mn сайтаар зарлагдсан.	70%
2.2	албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;	Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын журам"-ыг шинэчлэн боловсруулж төвийн захирлын 2023 оны А/07 дугаартай тушаалаар баталсан. Уг журам цахим хуудсанд байршсан. https://hdc.gov.mn/page/64/	70%
2.3	албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;	“Ил тод” цэсний “Ёс зүйн хороо” хэсэгт 2024 онд • Ёсзүйн хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө; • Ёс зүйн хорооны 2023 он, 2024 оны хагас жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан; • “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ” • Ёсзүйн дэд хорооны ажиллах журам • Төрийн албан хаагчийн ёсзүйн тухай хууль байршуулсан бол • Төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зүйл • Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчийн ёс зүйн хэм хэмжээ • “Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ажилтан, албан хаагчийн ёс зүйн дүрэм” • Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм • Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмүүдийг оруулсан 2025 онд • 2024 оны Ёсзүйн дэд хорооны тайлан	100%

		• 2025 оны Ёсзүйн дэд хорооны төлөвлөгөө ороод байна. http://www.hdc.gov.mn/page/95/	
2.4	хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;	Хүний нөөцийн стратегийг цахим хуудасны “Үйл ажиллагаа” цэсний “Хүний нөөцийн ил тод байдал” хэсэгт байршуулсан. http://www.hdc.gov.mn/page/64/	30%
2.5	хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд эдгээр үйл ажиллагаануудын талаарх мэдээллүүд цахим хуудсанд байршсан болно. Үүнд: 1. Албан хаагчдыг чадавхжуулах сургалтуудыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж мэдээг цахим хуудасны “Мэдээ, мэдээлэл” хэсэгт http://www.hdc.gov.mn/post-category/1/ 2. “Ил тод” цэсний “Ёсзүйн дэд хороо” хэсэгт Ёсзүйн дүрэм журмууд http://www.hdc.gov.mn/page/95/ 3. “Хүний нөөцийн ил тод” хэсэгт Сул ажлын байрнууд болон Хүний нөөцийн мэдээллүүд http://www.hdc.gov.mn/page/64/ 4. Авилгын эсрэг үйл ажиллагааны талаар болон МС-ны материалуудыг “Авлигын эсрэг” хэсэгт тус тус байршуулсан байна. http://www.hdc.gov.mn/page/96/	0%
2.6	албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.	“Ил тод” цэсний “Хяналт үнэлгээ” хэсэгт http://www.hdc.gov.mn/page/116/ Төвийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журмыг Захирлын 2023 оны А/99 дүгээр “Журам, загварыг шинэчлэн батлах тухай” тушаалаар батлан, цахим хуудсанд байршуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
Хэсгийн дундаж хувь			62%

Гурав.Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх

д/д	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
3.1	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл	2025 оны 5 сарын байдлаар 6 мэдээллийг www.info.shilendans.gov.mn болон байгууллагын www.hdc.gov.mn сайтад ил тод байршуулсан.	100%

3.2	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан	2025 оны 5 сарын байдлаар 6 мэдээллийг www.info.shilendans.gov.mn болон байгууллагын www.hdc.gov.mn сайтад ил тод байршуулсан.	100%
3.3	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг www.info.shilendans.gov.mn болон байгууллагын www.hdc.gov.mn сайтад ил тод байршуулсан.	100%
3.4	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ	2025 оны 5 сарын байдлаар 5 мэдээллийг www.info.shilendans.gov.mn болон байгууллагын www.hdc.gov.mn сайтад ил тод байршуулсан.	100%
3.5	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	2025 оны 5 сарын байдлаар 5 мэдээллийг www.info.shilendans.gov.mn болон байгууллагын www.hdc.gov.mn сайтад ил тод байршуулсан.	100%
3.6	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	2025 оны 5 сарын байдлаар 434,105,300 төгрөгийн 17 мэдээллийн www.info.shilendans.gov.mn болон байгууллагын www.hdc.gov.mn сайтад ил тод байршуулсан.	100%
3.7	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого зарлага мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт	2025 оны 5 сарын байдлаар 1,097,244,629 төгрөгийн 49 мэдээллийг www.info.shilendans.gov.mn болон байгууллагын www.hdc.gov.mn сайтад ил тод байршуулсан.	100%
3.8	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	2025 оны 5 сарын байдлаар 21 гэрээ, 27 тушаал, 13 удирдамж нийт 61 мэдээлэлийг www.info.shilendans.gov.mn болон байгууллагын www.hdc.gov.mn сайтад ил тод байршуулсан.	100%
3.9	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл	Хуулийн хугацаанд буюу 2025 оны 7 сард байршуулах болно.	-
3.10	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч	2025 оны 5 сарын байдлаар 94,489,000 төгрөгийн 17 мэдээллийг www.info.shilendans.gov.mn болон байгууллагын www.hdc.gov.mn сайтад ил тод байршуулсан.	100%

	мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл шалтгаан		
3.11	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт	Худалдан авах ажиллагаанд хийсэн 2024 оны аудитын тайлан, дүгнэлтийг www.info.shilendans.gov.mn болон байгууллагын www.hdc.gov.mn сайтад ил тод байршуулсан.	100%
3.12	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл	2025 онд 16 мэргэжилтэн худалдан авах ажиллагааны АЗ сургалтад хамруулан ажилласан. Уг арга хэмжээний талаарх мэдээллийг байгууллагын мэдээллийн сайтын холбогдох хэсэгт оруулаагүй байх тул хариуцсан нэгжээс хэрэгжилтийг хангаж ажиллах нь зүйтэй.	0%
3.13	Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн	2025 оны 5 сарын байдлаар 76,378,320 төгрөгийн 2 мэдээллийг www.info.shilendans.gov.mn болон байгууллагын www.hdc.gov.mn сайтад ил тод байршуулсан.	100%
3.14	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан	2025 онд Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан гэх мэдээлэл төвийн цахим хуудасны ил тод хэсэгт байршаагүй байна.	0%
	Хууль тогтоомжид заасан бусад	-	-
Хэсгийн дундаж хувь			84,62%

Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн

д/д	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
4.1	үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл,	1. Үйл ажиллагаа тус бүрээр мэдээллүүд байршуулж байна. Үүнд: - Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагаатай холбоотой - http://hdc.gov.mn/page/139/ - Мэргэшлийн зэрэгтэй холбоотой - http://hdc.gov.mn/page/33/ - Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй холбоотой - http://hdc.gov.mn/page/33/ - Гадаадын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрөлтэй холбоотой - http://hdc.gov.mn/page/28/	100%

		• Магадлан итгэмжлэлтэй холбоотой - http://hdc.gov.mn/page/91/ • Үндсэн мэргэшлийн сургалттай холбоотой - http://hdc.gov.mn/page/21/ • Төрөлжсөн болон дээшлүүлэх сургалттай холбоотой - http://hdc.gov.mn/page/22/ • Гадаад сургалттай холбоотой - http://hdc.gov.mn/page/23/ хууль, тогтоомж, эрхзүйн актууд орсон байна. “Хүний нөөцийн бүртгэл мэдээллийн сан” программд шалгалтын төлбөр, тэмдэгтийн хураамжийн төлбөр төлөх модулуудыг үүсгэн цахимаар төлбөр төлөлтүүд хийгдэж байна.	
4.2	тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл, зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа	Тус төвөөс Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэл, Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлийг олгох үйл ажиллагааг зохион байгуулдаг бөгөөд эдгээр зөвшөөрлүүдийн талаарх мэдээллүүд Цахим хуудасны “Хууль эрхзүй” цэсний “Сайдын тушаал” хэсэгт байршсан тушаалуудад багтдаг болно. https://www.hdc.gov.mn/file-category/102/	100%
Хэсгийн дундаж хувь			100%

Тав.Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал

д/д	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
5.1	Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал	Одоогоор санал авсан арга хэмжээ алга байна.	0%

5.2	эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт	Тус төв нь 1. 2017 оны 04 сарын 11-ний өдөр тууривсан “Эрүүл мэндийн статистик бүртгэлийн Health info3.0” програм хангамжийн зохиогчийн эрхийн 8743 тоот гэрчилгээг эзэмшдэг бөгөөд уг гэрчилгээг “Үйл ажиллаганы ил тод” хэсэгт байршуулсан байгаа. http://www.hdc.gov.mn/media/files/oyunii%20omchiin%20gerchilgee.pdf 2. 2020 оны 02 сарын 10-ний өдөр тууривсан “Хүний нөөцийн хөгжлийн систем” програм хангамжийн зохиогчийн эрхийн 11521 тоот гэрчилгээг эзэмшдэг бөгөөд уг гэрчилгээг “Үйл ажиллаганы ил тод” хэсэгт байршуулсан байгаа. http://www.hdc.gov.mn/media/files/oyunii%20omch%202.pdf	100%
5.3	мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл;	Тус төвийн эзэмшилд ЧД-ийн 11-р хороо Нуурын 18-390 хаягтай 977м2, https://hdc.gov.mn/media/files/2_O6hPooD.pdf СБД-ийн 1-р хороо, Энхтайвны гудамж 13в хаягтай 1457м2, https://hdc.gov.mn/media/files/1_E0TWYc3.pdf БЗД-ийн 6-р хороонд байрших 839м2 https://hdc.gov.mn/media/files/3_64Tz03c.pdf гэсэн 3 газар байгаа бөгөөд эдгээр газруудын талаарх мэдээлэл төвийн цахим хуудсанд байршсан байна.	100%
5.4	нэвтрэх ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл	Эдгээр мэдээллүүдийг байгууллагын www.hdc.gov.mn цахим хуудсанд байршуулж тухай бүрд нь шинэчлэн ажиллаж байна.	100%

	мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт	2024 1. Төрөлжсөн мэргэшлээр суралцах эмч, мэргэжилтний талаарх мэдээлэл https://www.hdc.gov.mn/media/uploads/2024_07/48e2abb7e4a54cd581ada3bb006fa5ef.pdf 2. Үндсэн мэргэшлийн чиглэлээр суралцах эмч, мэргэжилтний талаарх мэдээлэл https://www.hdc.gov.mn/media/uploads/2024_12/896ecf1323964052b23ccfc8512e5065.pdf 3. Монголд оношлох, эмчлэх боломжгүй өвчний эмчилгээг нутагшуулах чиглэлээр гадаад оронд суралцсан багуудын мэдээлэл https://hdc.gov.mn/media/files/gadaad%20suraltssan%20emch%20nar.pdf 4. Тус төвийн албан хаагчдыг сургалтын талаарх мэдээлэл https://hdc.gov.mn/media/files/surgaltii%20tailan%202024.pdf байршаад байна.	70
5.5	хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл	Эдгээр мэдээллүүдийг байгууллагын www.hdc.gov.mn цахим хуудсанд байршуулж тухай бүрд нь шинэчлэн ажиллаж байна.	0
Хэсгийн дундаж хувь			74%
Хэрэгжилтийн дундаж хувь			73.3%

Жич: Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдлын тайлангийн 6 зүйл нь Эрүүл мэндийн хөгжлийн төвд хамааралгүй байх тул хүснэгтэд оруулаагүй болно.

Зургаа. Цаашид анхаарах асуудал, зөвлөмж

Шалгуур үзүүлэлтийн дагуу байгууллагын “Цахим хуудас”-т байршуулах мэдээллүүдийн дийлэнх нь тусгай линкээр орж үзэж байгаа нь мэдээлэл ил тод, нээлттэй гэж үзэх боломжгүй байна.

ЭМХТ-ийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээг 2025 оны 6-р сарын байдлаар ил тод, нээлттэй байршуулах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэхэд **73.3** хувь буюу “Хангалттай” үнэлгээтэй байна. Үүнд:

- Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал-**46** хувь. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг ил тод байршуулаагүй;
- Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал - **62** хувь. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам; Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ зэрэг 2 мэдээллийг ил тод байршуулаагүй;
- Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал – **84.62** хувь;

- Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал - **100.0** хувь;
- Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал - **74** хувь. Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал; Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад (хүний эрх, жендэр болон бусад) мэдээллийг ил тод байршуулаагүй;

Мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн биелэлтийг сайжруулахын тулд дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд.

1. Ил тод, нээлттэй байршуулах мэдээллийг Цахим хуудасны нүүр цонхонд ямар нэг шат дамжлагагүйгээр шууд байршуулах.
2. Төвийн цахим хуудасны тогтмол мэдээллийг шинэчлэх, баяжилтыг тухай бүр хийх, мэдээллийг иргэнд ойлгомжтой байхаар байршуулж хэвших;
3. ЭМХТ-ийн 2024 оны үйл ажиллагаанд ЭМЯ-аас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах.
4. Цахим хуудаст оруулж байгаа мэдээ, мэдээллийн найруулга, үг үсгийн алдааг холбогдох нэгжийн дарга нар хянаж байх.
5. Төвийн пэйж хуудсаар түгээж байгаа зарлал, мэдээллийг Цахим хуудаст байршуулж хэвших.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЛБА